



Байгаль орчны судалгаа, үнэлгээний
зөвлөх “ЭРТЭЧ НАРАН” ХХК

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМАНД
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “ХАЯГДАЛ
АККУМЛЯТОР, ӨНГӨТ ТӨМӨРЛӨГ ДАХИН
БОЛОВСРУУЛАХ” ТӨСӨЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч: “ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

УЛААНБААТАР-2024 он

ГАРЧИГ

ОРШИЛ

1	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1	Ерөнхий мэдээлэл.....	1
1.1.1	Төсөл хэрэгжүүлэгч.....	1
1.1.2	Төслийн зорилго.....	1
1.1.3	Төслийн эзэмшлийн газар, үйлдвэрийн байршил.....	1
1.1.4	Газар ашиглалт.....	2
1.1.5	Үйлдвэрийн хүчин чадал.....	3
1.2	Төслийн талбай орчмын бүс нутгийн тодорхойлолт.....	3
1.2.1	Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт.....	3
1.2.2	Түүхий эдийн шинж чанар, үйлдвэрийн технологи.....	5
1.2.3	Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт.....	7
1.3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
1.3.1	Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт.....	8
1.3.2	Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол.....	9
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
2.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ.....	10
2.1.1	Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт.....	10
2.1.2	БОМТ-ний хамрах хүрээ.....	10
2.1.3	БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц.....	11
2.2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
2.3	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	13
2.4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ.....	15
2.5	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	15
2.5.1	Аваар осол гарсан онцгой байдлын үед авах арга хэмжээ.....	15
2.5.2	Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.....	15
2.5.3	Хүний эрүүл мэндийг хамгаалах.....	16
2.5.4	Хүхрийн хүчил, аюултай хаягдлын мэдээллийн сан, бүртгэл.....	18
2.5.5	Үйлдвэр танилцуулах аялалын аюулгүй байдал.....	18
2.6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
2.7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
2.8	2023 оны БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
2.9	2023 оны БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	25

ДҮГНЭЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ

ОРШИЛ

Төв аймгийн Баянцогт сумын нутагт хаягдал аккумулятор, өнгөт металл дахин боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа “Үлэмж хүдэр” ХХК нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах 2.0 га талбайг 15 жилийн хугацаатай эзэмшиж байна. Эзэмшил талбайн 54.0 хувьд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах ,хатуу хучилттай зам талбай тавих зэргээр идэвхтэй ашиглаж байгаа ба 0.88 га сул орон зайд ногоон бүс тохижуулах ажлыг эхлүүлсэн.

Үйлдвэрийн төсөлд 2019 онд “Төмөрлөг боловсруулах тусгай зөвшөөрөл” авсан бөгөөд 2020 онд төслийг “Аккумулятор дахин боловсруулах” төсөл болгон өөрчилж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “НЕРЖ” ХХК-аар хийлгэж байгаль орчны менесентийн 5 жилийн төлөвлөгөө бтлуулж байсан. “Аюултай хог хаягдал дахин боловсруулах” тусгай зөвшөөрлийг гаргуулан авч 2023 оноос үйл ажиллагаа нь жигдэрч байгаа бөгөөд одоо 2024 оны БОМТ боловсруулаад байна.

Үйлдвэр 2024 онд 1000 тн зэс, 3000 тн хаягдал аккумулятор, 32000 тн ширэм цуглуулж боловсруулах бөгөөд нийт 44.0 мянган тн/км тээврийн ажил хийнэ. Үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрийн урсгал засвар, ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, Баянцогт сумын ЗДТГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын ажлуудыг хийхээс гадна байгаль орчны болон хүний эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрийн бүс нутгийн оршин суугчид руу чиглэсэн нийгмийн сайн сайхны төлөө ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. БОМТ-нд нийт 52.818 сая төгрөгний зардал бүхий ажил төлөвлөсний 28.7 хувь нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулагдана.

Үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ-г боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ЭРТЭЧ НАРАН” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БОАЖЯ-наас 2019-10-29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 3 дугаар хавсралтын “Г”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

БОМТ-г нийт 2 бүлэг, 11 дэд бүлэгт багтаан 17 хүснэгт, 9 зураг, схем, график, загварчилал болон тооцооллыг нотлох 12 хавсралтаар баримтжуулсан.

“ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл

1.1.1 Төсөл хэрэгжүүлэгч

Төслийн нэр:	“Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Үлэмж хүдэр” ХХК
	Регистрийн дугаар: 6164439
	Бүртгэлийн дугаар 9011662110
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Баянзүрх дүүрэг, 25-р хороо, 13-р хороолол. Амины орон сууц-9. Монгол улс, Улаанбаатар хот.
Төслийн байршил:	Төв аймаг, Баянцогт сум, 2 дугаар буюу Сарлагт баг. Сарлагт гудамж
Холбоо барих:	Утас: +976- 9908-9969, +976- 8810-6868 Майл хаяг: ulemjkhuder@gmail.com

1.1.2 Төслийн зорилго

Маш хямд үнээр Хятад улсруу экспортолж буй хаягдал өнгөт төмөрлөгийг ангилах, байгальд хортой хаягдал үүсгэж буй хаягдал аккумуляторыг цуглуулах, тэдгээрт дулааны боловсруулах хийх замаар нэмүү өртөг бүтээж, валютын орлого олох нь энэ төслийн зорилго гэж төсөл санаачлагчид үзсэн байна. Төслийн зорилгын хүрээнд дараах зорилтууд хэрэгжинэ. Үүнд:

- Шинээр 20-25 орчим ажлын байрыг бий болгох, орон нутгаас ажилчин сургаж ажлын байранд байршуулах
- Мэргэжлийн чадварлаг, ажиллах бүтээлч сэтгэхүйтэй багийг бүрдүүлж, сургаж бэлдэх,
- Бизнесийн ашигтай үйл ажиллагаа эрхэлж улс, орон нутгийн төсөвт холбогдох татвар, хураамж төлөх замаар төсөв бүрдүүлэлтэнд оролцох.


1.1.3 Төслийн эзэмшлийн газар, үйлдвэрийн байршил

Төслийн эзэмшлийн газрыг төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2020 оны 6 сарын 29-ний өдрийн А/120 тоот шийдвэрийг үндэслэн 15 жилийн хугацаатайгаар нэгж талбарын 4117020121 дугаараар 20,000.0 м² газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байна.

Үйлдвэр нь Төв аймгийн Баянцогт сумын нутаг —Сарлагийн хөндий нэртэй газарт байрлана. Уг төсөл хэрэгжиж буй эдэлбэр газар нь Хангай бүсийн зүүн үзүүр, Хэнтий бүсийн баруун шувтарга болох завсрын бүсэд уулсын их хөндийд байрладаг ба Улаанбаатар хотоос баруун тийш 100 орчим км, Төв аймгийн төв Зуунмод хотоос баруун

Төв аймгийн Баянцогт сумын нутаг дахь “Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ “ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

хойшоо 130 орчим км, Баянцогт сумын төвөөс ургашаа 11 км-г, Сарлаг багийн төвөөс баруун тийш 1.0 км-г байршиж байна.



Зураг 1. Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэрийн байршлын зураг

1.1.4 Газар ашиглалт

Үйлдвэр нь эзэмшил газрынхаа 55.7 хувийг идэвхтэй ашиглаж байгаа ба идэвхтэй ашиглаж байгаа газрын ихэнх нь хатуу болон хайрган хучилттай зам талбай байж, үйлдвэрийн барилга байгууламж нийт эзэмшлийн талбайн 10.0 гаруй хувийг эзэлж байна.



Зураг 2. “Үлэмж хүдэр” үйлдвэрийн газар ашиглалтын одоогийн байдал, 2022-9 сар

Байгаль орчны судалгаа, үнэлгээний “ЭРТЭЧ НАРАН” ХХК-д боловсруулав.

Хүснэгт 1. “Үлэмж хүдэр” ХХК-ий эзэмшлийн газар ашиглалтын бүтэц

№	Үйлдвэрийн барилга байгууламжууд	Квад.м-ээр	хувиар
1	Аккумулятор боловсруулах үйлдвэр	800	4.0
2	Түлш жижиглэх цех	100	0.5
3	Хаягдал аккумуляторын хуванцар хайрцаг хадгалах байр	200	1.0
4	Халуун ус	30	0.2
5	Трансформаторын байр	6	0.0
6	Зэс гууль ширэм хөнгөнцагаан боловсруулах үйлдвэр	600	3.0
7	Ажилчдын байр	200	1.0
8	Нийтийн ариун цэврийн байр	15	0.1
9	Хаягдал шингэн хадгалах байр	132	0.7
10	Ажилчдын байр 2	200	1.0
11	Хоолны газар	150	0.8
12	Зэс гууль хадгалах агуулах	12	0.1
13	Хөнгөнцагаан хадгалах агуулах	12	0.1
14	Цахилгаан пүү 120 тн / жин /	120	0.6
15	Суурин кран	240	1.2
16	Ундны усны худаг	12	0.1
17	Хатуу хучилттай зам, талбай	2800	14.0
18	Хайрган хучилттай зам, талбай	5300	26.5
19	Хоёрдогч түүхий эдийн талбай	220	1.1
20	Сул талбай	8851	44.3
Нийт ашиглалттай талбай		11149	100.0

1.1.5 Үйлдвэрийн хүчин чадал

”Үлэмж хүдэр” ХХК-ий аюултай хаягдал боловсруулах үйлдвэр нь бүтээгдэхүүний захиалга болон эрэлтээс хамаарч жилд 3,000.0 тн хаягдал цуглуулж, 5,000.0 тн хаягдал боловсруулахад 150-180 хоног/жил горимоор ажиллана. Үйлдвэрт нийт 15 ажлын байр байна.

Хүснэгт 2. Үйлдвэрийн үйл ажиллагааны хүчин чадал

Д/д	Өнгөт төмөрлөг	Бүрэн хүчин чадлаар /жилд/			
		Цуглуулах	Хадгалах	Боловсруулах/хоногт	Тээвэрлэх
1	Зэс гууль	1000 тн	1500 тн	7200 тн / 20 тн	1500 тн
2	Хаягдал аккумулятор	3000 тн	2500 тн	5000 тн / 13 тн	2500 тн
3	Ширэм	32000 тн	40000 тн	20000 тн / 55 тн	40000 тн

Үйлдвэр ийм хүчин чадалтай байгаа ч 2024 онд хагас үйлдвэрлэл явуулж үйлдвэрийг өргөтгөх төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажилд орно.

1.2 Төслийн талбай орчмын бүс нутгийн тодорхойлолт

1.2.1 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

Газрын гадарга. Төслийн бүс нутаг нь ерөнхийдөө талархаг, хээрийн хэв шинжтэй тэгш гадаргатай. Газрын хэрчигдэл багатай, хуурай сайрууд төслийн талбайгаас алсуур

байршилтай нь гол онцлог болно. Эргэн тойрондоо тариалангийн талбай тархсан, газар ашиглалтын үндсэн хэлбэр нь бүс нутгийн хувьд газар тариалан-мал аж ахуй байх тул газарт үзүүлэх нөлөөллийн өргөн цар хүрээ нь ХАА-н эдэлбэртэй холбоотой байна.

Цаг уур: Төслийн хувьд хэрэгжих орчин нь эрс тэс уур амьсгалтай, хур тундасны хуваарилалт ургамал ургах хугацаанд ахиу орох боловч ерөнхийдөө хуурай хээрийн төлөвшилтэй. Агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай чиглэлд бүс нутгийн уур амьсгал өөрчлөгдөж хуурайшилт эрчимжиж байгаа нь цэгэн цөлжилтийн тархац хүрээ тэлэх, газар-бэлчээр доройтох гол шалтгаан болж байна. Хавар, намрын улиралд салхины хурд ихэсч, хүчтэй болон салхи болон шуургатай өдрийн тоо олширч байгаа нь төслийн болоод бүс нутгийн эмзэг тал болно.

Агаарын чанар: Уг төсөл хэрэгжих талбай нь хүн амын амьдрах бүсээс 4-11км зайтай, тухайн орчинд агаар бохирдуулах эх үүсвэр нь төсөл хэрэгжүүлэгч өөрөө болно. Тиймээс хээрийн задгай салхитай энэ орчинд агаарын бохирдол тогтвортой байх нөхцөлгүй, орон нутгийн сэвэлзүүр болоод аясын салхины нөлөөгөөр амархан замхарна.

Гадаргын болон гүний ус: Төсөл хэрэгжих талбай нь Туул голоос ойролцоогоор 100 орчим километр зайд оршдог ба түүнээс өөр гадаргын ил усгүй хуурай хээрийн орчилд төслийн талбай байршина. Бүс нутгийн хуурай сайруудаар шар усны болон уруйн ус урсах боловч урсацууд байнгын бус давтамжтай. Тиймээс төслийн усны хэрэгцээг газрын доорхи уснаас хангана.

Хөрсөн бүрхэвч: Төслийн бүс нутгаар хуурай хээрийн элсэнцэр хүрэн тарах бөгөөд усалгаагүй газар тариалан эрхэлдгээс өргөн хэмжээний газар нутагт хөрсний үржил шимийг дайчилсан байдалтай болсон тул бүс нутгийн хэмжээнд хөрс салхины элэгдэлд орсон байна. Нөгөө талаас элсэнцэр хөрсний шүүрүүлэх чадвар сайн тул хур борооны усны тогтоц муу, агаарын хэт халалтын үед чийгээ амархан алддаг зэрэг хэв шинжийн сул талаасаа шалтгаалаад шим тэжээлийн хувьд ядмаг, агрохимийн эмзэг ангилалд хамаарна.

Ургамлан нөмрөг: Төслийн талбайн ашиглалтгүй сул орон зайд шарилж лууль ургасан ба бүс нутгийн хэмжээнд тариалангийн технологийн нөлөөгөөр бэлчээрийн ургамал үндсэндээ тахлагдсан, тахлагдал ихэссэн зарим хэсгээр агь, хиаг голлох болж бүлгэмдэлт хэв шинж нь бүдгэрсэн байдалтай болсон байна. Хур тунадас багатай жил бэлчээрийн ургалт багасч газар нүцгэрэн доройтох ба энэ нь бүс нутгийн хэмжээнд ховор, үнэт ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлдөг учраас ховрын статустай ургамал төслийн талбай орчинд бүртгэгдээгүй.


Амьтны аймаг: Төслийн бүс нутгаар газрын өгөөж бага, эдэлбэр ихтэй байдлаас шалтгаалан жижиг мэрэгчид байх боловч жил бүрийн газар элдэншүүлэх үйл ажиллагаагаар үүр ноохойг байнга хөндөж байдгаас шалтгаалан олон тоо толгойтой болж өсдөггүй байна. Жижиг мэрэгчдээр хооллох үнэг, хярс зураг хөхтөн амьтад хээрийн задгай

нөхцөл орогнох, нуугдах боломжтой байгаагаас шалтгаалан гүйдэл нь мөн цөөн байна. Төслийн талбайг 2м өндөртэй бетон блокоор хашаалж, үйлдвэр-техногений бичил орчин үүсгэсэн тул зэрлэг амьтад орогнох боломжгүй нөхцөлтэй болсон.

Бүс нутгийн амьдрах орчны чухлын зэрэг. Төслийн талбай, түүний орчны экологийн үзүүлэлтүүдийг бүхэлд нь авч үзвэл амьдрах орчны чухлын зэргээр өөрчлөгдсөн бүс нутагт тооцогдоно. Өөрчлөгдсөн бүс нутаг гэдэг нь нөлөөллийн индексийн утга хамгийн их буюу нөлөөлөлд хамгийн их өртсөн 5%-ийн утга бүхий үзүүлэлттэй нутаг болсон байна. Нөлөөллийн индекс гэдэг нь хүний үйл ажиллагааны нөлөөллийн хуримтлагдах байдал, эсвэл түүхэн болон байгалийн нөхцөл байдлаас хэр зэрэг өөрчлөгдсөнийг харуулах хэмжээс юм. Өөрчлөгдсөн бүс нутагт газар эдэлбэрийг үйлдвэр-үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах нь зүйтэй гэж үзэж ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалах бодлого баримтлахыг зөвлөдөг.

1.2.2 Түүхий эдийн шинж чанар, үйлдвэрийн технологи

Түүхий эдийн физик-химийн шинж чанар. Аккумулятор нь эерэг ба сөрөг электродуудын хагас нэгтгэлүүд, сепараторууд, эдгээрийг суулгах зургаан тасаг бүхий гэр, тасгуудыг таглах бөглөө бүхий тагнууд, элементүүд хоорондын холбогч, туйлуудын гаралтын шонгууд болон хамгаалатын тор зэргээс бүрддэг. Стартерт хар тугалгат хүхрийн хүчлийн H_2SO_4 аккумуляторын баттерей нь цуваа холбогдсон зургаан ширхэг хоёр вольтын аккумуляторуудын зургаан тасгаас тогтоно.



Зураг 3. Стартерт хар тугалгат хүхрийн хүчлийн H_2SO_4 аккумуляторын баттерейн бүтэц

Аккумуляторын хийцэд хүхрийн хүчлээс гадна 7-8% сурьма ба 0.1-0.2% мышьякийн нэмэлт хольц бүхий хар тугалга- сурьмагийн хайлш оролцдог ба хайлш нь цэвэр хар тугалгыг бодвол цутгагдах шинжээрээ илүү сайн өндөр, 0.1-1%-ийн кальцийн агууламжтай.

Аккумуляторын электролит шингэн: Мөн аккумуляторын электролит шингэн нь цэвэр хүхрийн хүчил H_2SO_4 ба ус H_2O -ны уусмал бөгөөд ашиглах орчны температурт тохируулж тодорхой харьцаагаар найруулсан байдаг учраас хуучин аккумуляторийг задалж боловсруулалтанд оруулах нь аюултай ажиллагаанд тооцогдоно. Электролит шингэнийг найруулах харьцааг шингэний нягтаар хэмжиж тодорхойлох ба хүйтэн бүс нутагт өвлийн улиралд 1.28г/см³-1.31г/см³, зуны улиралд 1.26г/см³-1.28г/см³ байна.

Хүснэгт 3. Хүхрийн хүчлийн хор аюулын тэмдэглэгээ

Ангилал	Шошго			Аюулын тэмдэглэгээний код	
	Аюулын зэрэглэл	Анхрааруулах тэмдэг	Дохио үг		
Арьс үрэвсүүлэгч ч ба цочроогч бодис	1	Зэврүүлэгч GHS05	Аюултай	Арьс, нүдийг, хүчтэй түлж гэмтээнэ.	H314
Металл зэврүүлэгч бодис	1	Зэврүүлэгч GHS05	Анхаар	Металлыг зэврүүлнэ	H290

Үйлдвэрийн технологи. Хаягдал аккумулятор, өнгөт металл боловсруулах үйлдвэр нь хими бодис-дулаан боловсруулалтын суурьтай.



Зураг 4. Хаягдал батареи боловсруулах технологийн дамжлагын схем

Хог хаягдал. Аккумулятор задалж боловсруулах явцад үйлдвэрээс гарах хог хаягдлыг үйлдвэрийн болон ахуйн гэж ангилна.

Хүснэгт 4. Хаягдал аккумулятор боловсруулах үйлдвэрийн хог хаягдлын ангилал

Үйлдвэрийн буюу технологийн хог хаягдал	Ахуйн хог хаягдал
<p>Хатуу хаягдал:</p> <ul style="list-style-type: none"> Аккумулятлоын хуванцар эд анги Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварын хаягдал Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан (хуучин хувцас, гутал,) хатуу хаягдал <p>Шингэн хаягдал:</p> <ul style="list-style-type: none"> Аккумуляторын электролит хуримтлагдсан шингэн 200.0 тн байгаагаас хэсэгчилэн устгалд оруулна. Үйлдвэрийн усыг эргэлтээр ашигласнаар блхирдуулах бодисын хэмжээ 324 кг болно. 	<p>Хатуу хаягдал:</p> <ul style="list-style-type: none"> Хүнсний сав баглаанаас гарсан дахин ашиглах боломжтой (шил, лааз, хуванцар сав) хаягдал Бичиг хэргийн аюултай болон энгийн хаягдал Барилга байгууламжийн ашиглалтаас гарах хатуу (цахилгааны утас, гэрлийн шил) хаягдал Дахин ашиглах боломжгүй хэт бохир хаягдал <p>Шингэн хаягдал:</p> <ul style="list-style-type: none"> Ажилчдын үйлчилгээний ахуйн бохир ус Нийтийн хоолны үйлчилгээний ахуйн бохир ус Ахуйн шингэн хаягдлын нийт хэмжээ 216.0 м³/жил

1.2.3 Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Сумын мэдээлэл. Баянцогт сум 147198 га нутаг дэвсгэртэй. ХАА-н эдэлбэр газар 130705 га буюу 88.7 хувийг эзэлдэг ба тус суманд 56 аж ахуйн нэгж 18993 га газар эзэмшдэгээс суманд бүртгэлтэй 14 аж ахуйн нэгж 5576 га эзэмшиж байна. Сумын үндсэн үйлдвэрлэл нь газар тариалан, жимс жимсгэнэ, хүнсний ногооны тариалан, мал аж ахуй эрхлэлт ба төслийн үйлдвэр тус суманд хөгжих үйлдвэрийн эхлэлийг тавьж байгаа юм. Сумын төвд төвлөрсөн үсчин гоо засал, гэрэл зураг, цайны газар, талх нарийн боов, ус түгээлт, халаалт гэсэн жижиг үйлдвэр, үйлчилгээнүүд тогтвортой үйл ажиллагаа явуулж орон нутгийн хэрэгцээг хангаж байгаа болно.

Тус сум нь нийт 324 өрхийн 1838 хүн амтайгаас үүний 18 орчим хувийг хөдөлмөрийн насны ажил горилогч нар эзэлж байгаагаас үзвэл Төв аймгийн бусад сумдтай харьцуулж үзэхэд их тоо юм. Баянцогт сум нь тус бүр 120-160 өрх бүхий Гуна, Сарлаг, Даргиат гэсэн 3 багтайгаас Сарлаг баг нь 43510 толгой малтай, малынхаа тоогоор сумандаа тэргүүлдэг байна.

Төслийн дэд бүтэц. Үйлдвэр бие даасан үйл ажиллагаагаа хангахад өөртөө дэд бүтцийн дараах сүлжээг шийдсэн.

Хүснэгт 5. “Үлэмж хүдэр” ХХК-ий Баянцогт сум дахь үйлдвэрийн дэд бүтцийн шийдэл

№	Дэд бүтцийн шаардлага	Эх үүсвэр	Хүчин чадал
1	Цэвэр усны хангамж	Өөрийн эзэмшлийн гүний худаг.	65 м-ийн гүн цооногтой, ус нь 15м-ийн түвшинд тогтсон NGERSELLAND-900 маркийн насостой худаг байна. Худгийн ашиглалтын усны ударга нь 1.3 л/сек
2	Эрчим хүчний хангамж	Улаанбаатар цахилгаан дамжуулах агаарын 110 кВт-ын шугам	ЦДАШ-аас салаалсан 220 кВт-ын хүчин чадалтай хэрэглэгчийн түгээх шугам
3	Үйлдвэрийн дулаан хангамж	Эрчим хүчний шугам	Үйлдвэрийн дулаан боловсруулалтаас татсан богино эргэлтийн бие даасан шугам
4	Зам, тээвэр	Улаанбаатар-Лүнгийн хатуу хучилттай улсын автозам	Тус автозамаас Аргалантын орчимд салаад Баянцогт сум руу орон нутгийн хөрсөн замаар холбогдоно.

1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

1.3.1 Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт

Хоёрдогч түүхий эд ашиглаж нэмүү өртөг бий болгох энэхүү төсөл нь уул уурхай, олборлох салбартай харьцуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлаараа сөрөг нөлөө бага, нөлөөллийн эрчим сул гэж тогтоогдсоноос гадна хамгийн гол нь нөлөөллийн цар хүрээ төслийн талбайгаас гадагшлах нөхцөлгүй юм.

Хүснэгт 6. Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт

№	Төслийн хүрээний сөрөг нөлөөллийн асуудал	Сөрөг нөлөөллийн хэмжээст параметрууд	Тайлбар
1	Цэвэр усны нөөцийг газрын доорхи гүний уснаас хангана.	<ul style="list-style-type: none"> Унд ахуйн хаягдал ус 216.0м³/жил 	Ахуйн шингэн хаягдлыг бохирын энгийн цооногт хуримтлуулна.
2	Усыг эргэлтгээр ашиглахгүй, байгальд бохир ус хаяна.	<ul style="list-style-type: none"> Бохирдуулах бодисын хэмжээ 324 кг 	Септик технологийн систем 3 үе шаттай, цэвэршилтийн түвшин 50-60 хувь
3	Төслийн талбайн хөрсний бохирдол	Хөрсөнд аюултай химийн бодис нэвчиж болзошгүй бөгөөд нөлөөлөл төслийн талбайгаас гадагшлахгүй.	Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батерейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS 6783:2019
4	Төслийн талбайн ургамлан нөмрөгийн тахлагдал	Барилга байгууламж бүхий орон зайн хэмжээгээр ургамлан нөмрөг устсан.	Сул орон зайд ногоон бүс тохижуулах боломжтой.

Үлэмж хүдэр ХХК-ын хаягдал өнгөт төмөрлөг, аккумулятор дахин боловсруулах үйлдвэр төсөл хэрэгжсэнээр байгалийн гадаргын усанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй.

Үйлдвэрийн ажилчдын буюу ахуйн хэрэглээний усыг Септик технологиор 50-60 хувь цэвэршүүлнэ. Үйлдвэрийн төслийн хэмжээнд ашиглаж буй гүний усны ашиглалтын түвшинг хянаж, үйлдвэрлэлийн процессд хаягдал усыг дахин ашиглах технологитой нь гүний усны түвшний бууралтыг хязгаарлах, ундарга багасах сөрөг нөлөөллийг бууруулж байна гэж үзэж байна. Мөн ундны усны ундаргын эрүүл ахуйн бүс /худгийн байшин, хашаа, хайс, цоож/ ийг байгуулж бохирлогдохоос сэргийлсэн нь дээрх сөрөг нөлөөллийг бууруулахад түлхэц болж байна.

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурьдсан хууль, эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллах хэрэгтэй. Энэхүү төслийн гол сөрөг нөлөөллийн эхнийх нь богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд бөгөөд тэдгээрийн эрч хүч, хамрах хүрээ, хугацаа нь барилгыг барих үеийн удирдлага зохион байгуулалтын арга ухаантай багагүй холбоотой байна. Сүүлчийнх нь байгууламжийг эзэмшигчдийн өөрсдийн нь үйл ажиллагаатай шууд холбоотой нөлөөлөл гэж үзэж болно.

1.3.2 Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол.

Дэлхий даяар жил бүр ойролцоогоор 99 сая хар тугалга-хүчлийн аккумулятор үйлдвэрлэж, тэдгээрийн 98 гаруй хувийг эргүүлэн ашиглаж байна. Хөгжсөн орнууд ашиглагдсан аккумулятороос ялгасан хар тугалга ба хуванцрыг боловсруулан шинэ аккумулятор үйлдвэрлэхэд дахин ашиглах замаар аккумуляторыг задалж боловсруулан эдийн засгийн эргэлтэнд оруулж байгаа юм.

Манай улсын хэмжээнд 610 орчим мянган машин, өчнөөн тооны мотоцикль, үүн дээр хөдөө орон нутагт байгаа 80 гаруй мянган нарны зайн үүсгүүрүүд бүгд аккумулятоор ажиллаж, жил бүр 4-5 мянган тонн хар тугалга хаягдал болон хуримтлагдаж байгааг дахин боловсруулж, шинэ ажлын байр, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн гаргаж байгаа нь энэ төслийн нийгмийн ач холбогдолыг тодорхойлно.

Эс бөгөөд аюултай хог хаягдалд тооцогдох ашиглалтгүй болсон аккумуляторуудыг устгалд оруулах нийгмийн хурц шаардлага тулгарах болж энэ нь эдийн засгийн хувьд ямар ч үр ашиггүй, илүүц зардлаар байгаль орчноос тодорхой хэмжээний орон зайг тусгайлан аюултай хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа байх болно.

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ

2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

БОМТ-ний гол зорилго нь үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж эрх бүхий байгууллагаар батлуулах, гүйцэтгэлийг хангуулж хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг тайлангахад оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд 2024 онд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах
- Үйлдвэрийн орчинд ногоон бүс тохижуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авах
- Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх
- БОМТ-ний биелэлт, сумын захиргаатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг орон нутагт тайлагнах зэрэг ажил болно.

2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 2024 оны БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “ХАА, үйлдвэрлэл”-ийн төслийн ангилалд хамаарна.

БОМТ-ний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагааны баримт бичгийн бүрдүүлбэрт дараах материалуудыг бэлтгэсэн. Үүнд:

- 2019-7-29-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олгосон “Төмөрлөг боловсруулах тусгай зөвшөөрөл”
- Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2020-6-29-ний А/120 тоот шийдвэрийг үндэслэн 15 жилийн хугацаатайгаар олгосон 20,000.0 м² газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмших эрхийн 6220 тоот гэрчилгээ.
- 2020 онд БОАЖЯ-нд Хаягдал өнгөт төмөрлөг, аккумулятор дахин боловсруулах үйлдвэрийн төслийн “НЕРЖ” ХХК-д боловсруулсан БОННУ-ний тайлангийн баталгаажилт, 2025 он хүртэл хүчинтэй
- 2022-4-20-нд Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Аккумулятор дахин боловсруулах” төсөлд олгосон Аюултай хог хаягдал дахин боловсруулах тусгай зөвшөөрөл

- 2022-01-17-нд Төв аймгийн ОБГ-аас олгосон Ажлын байрны галын аюулгүй байдлын 2024309 гэрчилгээгээр баталгаажсан дүгнэлт, 2 жилийн хугацаатай
- 2021-11-30-ны Туул голын сав газрын захиргааны ХУД/121 тоот хаягдал усны дүгнэлт
- 2022-08-01-ний Баянцогт сумын Засаг даргатай байгуулсан Ус ашиглах гэрээ
- 2022-07-27-нд Баянцогт сумын засаг даргатай байгуулсан Нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ
- 2022-07-27-нд Баянцогт сумын засаг даргатай байгуулсан Хог хаягдлын гэрээ.
- 2023 оны 5 сарын 10-нд Баянцогт сумын ЗДТГ-ын нийгмийн хариуцлагын хүрээд хамтран ажиллах гэрээ
- 2023 оны 11 сарын 15-ны өдөр Баянцогт сумын засаг даргатай байгуулсан Хог хаягдлын гэрээ
- 2023 оны 11 сарын 15-нд сумын засаг даргатай байгуулсан Ус ашиглах гэрээ

2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц

2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 61.82 сая төгрөг төсөвлөгдөж байгаа ба түүний 28.7 хувийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, 24.6 хувийг осол эрсдлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулна.

Хүснэгт 7. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардал

№	БОМТ-гөөр хийх ажил	Тооцсон зардал	
		төгрөг	хувь
1	Сөрөг нөлөөг бууруулах	3,988,800.00	7.6
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	15,550,000.00	12.4
3	Түүх, соёлын өвийг хамгаалах	-	
4	Осол эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх	16,679,500.00	31.6
5	Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх	3,916,200.00	7.4
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15,184,000.00	28.7
7	Удирдлагын менежмент	6,000,000.00	11.4
8	БОМТ-г оршин суугчдад тайлагнах	500,000.00	0.9
Нийт зардлын дүн		61,818,500.00	100.0

2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх дараах сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг агаар, орчны бохирдлын сөрөг нөлөөг бууруулах, газар, хөрсний бохирдлыг бууруулах, газрын доорхи усны нөөцийг бохирдлоос хамгаалах чиглэлд тус тус хийнэ. Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэхэд 3,9 сая төгрөг зарцуулах бөгөөд энэ нь БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардлын 8.79 хувь нь болно.

Төв аймгийн Баянцогт сумын нутаг дахь “Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ
 “ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

Хүснэгт 8. Үйлдвэрлэлээс үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Орчны бохирдлын сөрөг нөлөөг бууруулахад									
1	Орчны бохирдлын сөрөг нөлөө	Могой хэлбэрийн яндангийн урсгал засварыг хийх		удаа	Үйл ажиллагааны зардалд тооцож тусгасан.			жилд 3 удаа	MNS 6783:2019 Ашиглалтаас гарсан хар тугалгалт-хүхрийн хүчлийн батарсйг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага
2		Янданд даавуун шүүлтүүр солих		ширхэг	8,820.0	340	2,998,800.0	жилдээ	
Газар хөрсний бохирдлын болзошгүй сөрөг нөлөөг бууруулахад									
3	Газар, хөрс бохирдож болзошгүй	Ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ.	Ажилдчын хэрэгцээний нүхэн жорлонгийн орчин	удаа	Хог хаягдлын менементийн зардалд тооцогдсон			2 сард 1 удаа	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4		Хуримтлагдсан бохир лагийг цэвэрлэх	Септик систем, түүний орчин	удаа	Хог хаягдлын менементийн зардалд тооцогдсон			Хагас жилд 1 удаа	
Гүний усыг бохирдлоос хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөг бууруулахад									
5	Газрын доорхи ус бохирдож болзошгүй	Хамгаалалтын хашаа хийнэ	Гүний худгийн хамгаалалт хийх	м	16500	60	990,000.0	2-р улиралд 1 удаа	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл Ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт		2,998,800.0 + 990,000 = 3,998,800.0 төгрөг							

2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

2.3.1 Ногоон бүс тохижуулах урт хугацааны төлөвлөлт

Үйлдвэр үйлдвэрийн хашаан дотроо ногоон бүс тохижуулж хүрээлэн буй орчны чанарыг сайжруулахад 2035 оныг дуустал буюу газар ашиглалтын эрхийн хугацааны туршид хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөг боловсруулсан. Ногоон бүс тохижуулах урт хугацааны төлөвлөлтийг цаг хугацааны дараах хувиарлалтанд авч үзсэн болно.

№	Хийх ажлын дараалал	Ногоон бүс тохижуулах жилүүд												
		2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035
1	Мод сөөг тарьж ногоон бүс дэх модны тоог жил бүр 250-300 ширхэгээр нэмэгдүүлнэ	[Green bar from 2023 to 2028]												
2	Ногоон бүс тохижуулах дизайн зураг төсөл хийж, холбогдох зардлыг жил бүрийн төсөвт хувиарлана.	[Green bar from 2024 to 2025]												
3	Саравч сүүдвэрч хийж, амралтын цэг байгуулна.	[Green bar from 2024 to 2027]												
4	Ногоон бүсийн усалгааны танк байрлуулж, усалж арчилна.	[Green bar from 2024 to 2035]												
5	Ногоон бүсийг хамгаалж жижиг хайс хийнэ	[Green bar from 2024 to 2025]												
6	Ногоон бүс дэх явган замыг тохижуулна.	[Green bar from 2025 to 2026]												
7	Өвслөг ургамлыг баяжуулж, нутгийн цэцэгт ургамал нэмж ургуулна.	[Green bar from 2026 to 2032]												
8	Ногоон бүсийн арчилгаа тордолтыг хийж, шарилж-луулийг зулгаана.	[Green bar from 2023 to 2035]												

Зураг 5. Үйлдвэрийн хашаанд ногоон бүс тохижуулах урт хугацааны төлөвлөлт

Компани 2024 онд нийт 2150 мод тарих ба түүний:

- 150 ширхэгийг үйлдвэрийн хашаандаа,
- 2000 ширхэгийг нь Баянцогт сумын нутагт аймаг болон сумаас зааж өгсөн газарт тарьж ургуулна.

2.3.2 Үйлдвэрийн ногоон бүсэд хийх ажлын 2024 оны төлөвлөлт

Үйлдвэрийн орчинд хэд хэдэн газар хэсэгчилсэн байдлаар ногоон бүс үүсгэсэн бөгөөд тэдгээрийг цаашид өргөтгөх, нэмж тохижуулах ажлыг 2024 онд үргэлжлүүлэн хийнэ. Үйлдвэрийн бүсийн ногоон бүсэд 2023 онд шинээр 300 мод нэмж тарьсаныг усалж, арчилах бөгөөд 2024 онд 150 мод нэмж тарьна.



Зураг 6. Үйлдвэрийн бүсийн ногоон бүс болон шинээр мод тарих газрын байршил

Үйлдвэрийн хашаанд хээрийн хуурай нөхцөлд ургах чадвартай хайлаас тарихаар сонгож байгаа бөгөөд мод тарих ажлыг ажилчдын хүчээр хийх ба гол зардал хайлаасыг үйлдвэрийн талбайд авчрахтай холбоотой ажилд зарцуулагдана.

2.3.3 2000 мод тарих ажил

2023 оны төлөвлөлөгөөний биелэлтийн тайланг баталгаажуулах явцад Төв аймгийн Байгаль орчны газраас тавьсан шаардлагын дагуу 2000 ширхэг модыг 2024 оны үйл ажиллагааны жилд тарьж ургуулна. Мод тарих газрыг аймгийн байгаль орчны газраас зааж өгөх бөгөөд тарьц, суулгацыг бэлтгэх, тэвэрлэх, тарих ажлыг компанийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Хайлаас, улиас нь манай аймгийн цаг уурт маш сайн зохицсон хоёр настайгаас 3 настай суулгацыг сонгож зааж гэсэн газарт тарьж ургуулна. Модыг тарихдаа вегетацийн хугацаа эхлэхээс өмнө 4-р сарын 15-наас 5-р сарын 25 хүртэл, намар 10-р сарын 1-нээс 11-р сард хүйтрэх хүртэл хугацаанд суулгана. Модыг тарих үед үндсийг хатаахгүй байх нь чухал байдаг тул тарих нүх болон бусад багаж хэрэгслийг бэлтгэсний дараа тарьцыг үндэс орчмын шороотой зөөвөрлөнө. Мод тарих нүхийг бэлтгэхдээ 50 см диаметртэй, 50-60 см гүнтэй байхаар ухна. Суулгаж байгаа модныхоо үндсийг нугалахгүй байх тал дээр анхаарах ба модыг суулгахдаа мод услах тогоог заавал гаргаж өгнө. Тогоо нь газрын гадаргуугаас 5-10 см дор ойролцоогоор 40-50 л ус багтахаар байна. Модоо суулгасны дараа хөрсийг сайн нягтруулан гишгэж, гол ишнээс хөнгөхөн татахад хөдөлгөөнгүй байх ёстой.

Хүснэгт 9. Тарьц, суулгац нийлүүлэхэд хамтран ажиллах байгууллагууд

№	Байгууллагын нэр	Холбоо барих	Гол үйлчилгээ
1	Соёолж цэцэгжилтийн төв	7777-5080	Төв аймгийн Баянчандмань сумын нутагт 50 га газарт нарс, гацуур, шинэс, улиас, хайлаас, гүйлс зэрэг 20 гаруй төрлийн модны тарьц суулгац бэлтгэдэг.
2	Төгөл мод үржүүлэг	9917-0889	Мод, бут сөөг, жимсний модны суулгац үржүүлэх, худалдах үйлчилгээ эрхэлдэг.
3	Мөнх ногоон тал ТББ	7018-7878, 9308-7878, 9905-0505, 9907-0006	Мод үржүүлгийн газарт үрээр гацуур, нарс, голт бор, гүйлс, буйлс, монос, агч, хайлаас, мөчрөөр улиас зэрэг мод сөөгний үржүүлэг хийдэг.
4	Байгалиа дээдлье ХХК	99585858	Мод, бут сөөгийг нугагшуулан тарималжуулах ажлыг хийж
5	Ногоон харш ХХК	91914026	Нийт 50 гаруй төрлийн гоёлын мод бут сөөг болон жимсний модны тарьц, суулгац бэлтгэдэг.

Төв аймгийн Баянцогт сумын нутаг дахь “Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ
 “ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх ажлын зардал

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Үйлдвэрийн хашаан доторхи ашиглалтгүй талбай	Шинээр мод сөөг тарина.	Үйлдвэрлэлийн ногоон бүс	квад.м	750	1200	900,000.00	жилдээ	<ul style="list-style-type: none"> MNS 5973:2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ
		Шинээр 150 ширхэг мод нэмж тарьна.	ажилчдын хүчээр	төлөвлөсөн талбайн хэмжээгээр	150	35,000.0	5,250,000.0	жилдээ	
		Ногоон бүсэд байршуулсан мод, сөөгийг усална	Үйлдвэрийн ногоон бүс	удаа	2	200,000.0	400,000.0	жилдээ	
2	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Аймгийн даалгавраар мод тарих	Аймгийн Байгаль орчны газраас зааж өгсөн газарт	ширхэг	2000	4,500.0	9,000,000.0	жилдээ	2023 оны БОМТ-ний биелэлтийн дүгнэлт №17, 2023-03-04
Нийт		900,000.00 + 5,250,000.0 + 400,000.0 + 9,000,000.0 = 15,550,000.0 төг.							

2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

Үйлдвэрийн бүс нутагт түүх дурсгалын биет зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд үйлдвэр нь 2.0 га талбай ашиглаж, үүссэн нөлөөлөл нь төслийн талбайгаас гадагшлахгүй тул түүх, дурсгалт зүйлсийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байхгүй.

2.5 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Үйлдвэр “Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батерейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS 6783:2019” стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.5.1 Аваар осол гарсан онцгой байдлын үед авах арга хэмжээ

1. Онцгой байдал, аваар ослын үед хүн гэмтэх, осол хүрээлэн буй орчинд тархах, зэргэлдээх барилга байгууламжид тархахаас сэргийлэхийн тулд:

- Аюултай бүсийг 200 м-ээс багагүй радиустай тусгаарлах бүсээр тусгаарлах;
- Галын аюулгүй байдлыг хангах үүднээс тамхи татах, оч, гал гаргах зэргийг хориглох;
- Бэртэж гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;
- Аваар осол гарснаас хөрс, усан сан зэрэг хүрээлэн буй орчинд бохирдол тархахаас сэргийлж орц, гарцыг хаах, үйлдвэрийн бүсэд хаалттай арга хэмжээ авах

2. Онцгой байдал, аваар ослын үеийн үйл ажиллагааны дараалал:

- Хүхрийн хүчил асгарсан, урссан, сав баглаа боодол задарсан тохиолдолд: Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батерейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS 6783:2019” стандартад заасан арга хэмжээг авна;
- Гал түймэр гарсан тохиолдолд: Гал гарсан тухай зарлан мэдээллийг онцгой байдлын үеийн журмаар зарлаж, галыг унтраахтай холбоотой арга хэмжээг авна. Үүнд: Ажилчдын хүчийг ашиглах, гал унтраах багт дуудлага өгөх, эмнэлгийн яаралтай тусламж дуудах, онцгой байдлын албанд дуудлага өгөх, гал унтраах хэрэгсэл /гал унтраагч, элс г.м/ гал команд иртэл байгаа нөөц бололцоогоо ашиглан /гал унтраагч, элс г.м ашиглан / галыг унтраах, хүмүүсийг галын голомтоос гаргаж аюулгүй бүсэд хүргэх зэрэг ажиллагааг хамруулахаас гадна ажилчдыг байнгын бэлтгэл сургалтаар хангана.

2.5.2 Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Тэмдэг, тэмдэглэгээ хийх. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажилчдын байрны орчинд эрүүл ахуй хамгаалалтын бүсийг хаягдал болон бохирдлын цэгээс 20 м-ийн алсалттай тогтоож халдвар хамгааллын дэглэм сахина.
- Түүхий эдийн болон хүхрийн хүчлийн агуулахын нярав болон техникийн ажилтнууд болон ажиллагсдын аваар ослын үеийн ажил үүргийн хувиарлалт гаргах ба аваар ослын талаар заавалд мэдэгдсэн байх шаардлагатай албан тушаалтнуудын нэрс, харилцах утасны дугаар зэргийг тусгасан байна.
- Түүхий эдийг агуулахад хүлээн авсан болон агуулахаас гаргасан, үйлдвэрлэлд ямар хэмжээтэйг хэрэглэсэн зэрэг бүртгэл тэмдэглэлийг хийж бүртгэлжүүлнэ.



Зураг 7. Үйлдвэрийн орчинд болон агуулахад хэрэглэх анхааруулах тэмдгүүд

2.5.3 Хүний эрүүл мэндийг хамгаалах

Ажилчдад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай ойлголтыг хөдөлмөр хамгааллын сургалтаар дэлгэрэнгүй өгч ослын үед авах яаралтай тусламж, зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүн нэг бүрийн үүргийг тодорхой болгож заасан байна. Энэ тухай шинчилс эн хөтөлбөрт маш тодорхой оруулна.

Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа оруулах үйлчилгээг Баянцогт сумын эүүл мэндийн төвөөс авч үйлчлүүлнэ. Үүнтэй холбоотой зардлыг сөрөг нөлөөллийг бууруулах хэсэгт тооцсон бий.

Хүснэгт 11. Хүний эрүүл мэндийг хамгаалах

Химийн бодисууд	Хүний биед нэвтрэх зам	Хамгааллын арга хэмжээ
Хүхрийн хүчлийн хордлогын үед	Амьсгалын замын хордлогын үед	Хордсон хүнийг агаартай газар гаргаж тайвшруулж, цэвэрхэн, дулаан хувцас өмсүүлэх; Хамар болон амыг цэвэр усаар сайтар зайлуулах, шаардлагатай бол эмнэлэгт хандах
	Биеийн арьс бохирдсон бол:	Арьсны бохирдсон хэсгийг усаар сайтар угаах, шаардлагатай бол эмнэлэгт хандах
	Хүчил нүдэнд орсон тохиолдолд:	Нүдээ анилгүйгээр урсгал усаар 15 минутын туршид болгоомжтой угаах /Нүдээ угаахдаа контакт линз зүүдэг бол линзээ авах/, шаардлагатай бол эмчид хандах
	Амаар залгисан тохиолдолд	Бага зэргийн давстай ус эсвэл нүүрсэн эм, ус их хэмжээгээр уух шаардлагатай бол эмнэлгийн тусламж авах
Химийн бодисын хордлогын	Амьсгалын замаар хордсон үед:	Цэвар агаартай орчинд гаргах, тайван, дулаахан байлгах. Халуун цай, кофе уулгах. Шаардлагатай бол эмчид үзүүлэх
	Арьс бохирдсон	Бохирдсон хэсгийг ихээхэн хэмжээний усаар сайтар угаах.

Химийн бодисууд	Хүний биед нэвтрэх зам	Хамгааллын арга хэмжээ
үед	бол	Шаардлагатай бол эмчид үзүүлэх.
	Нүд бохирдсон бол:	Нүдээ анилгүйгээр урсгал усаар 15 минутын турш сайтар угаах. Шаардлагатай бол эмчид үзүүлэх.
	Амаар залгисан тохиолдолд:	Их хэмжээгээр ус уух, нүүрсэн эм эсвэл сульфат натрийн /тал аяга усанд 1 хоолны халбагаар хийх/ уусмал уух. Шаардлагатай бол эмчид үзүүлэх.

Компанийн зүгээс хувийн хамгааллын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээг авдаг ба үүнтэй холбоотой зардлыг жил бүрийн үйл ажиллагааны төсөвт суулгаж өгдөг онцлогтой.

2024 онд “Ажилчдын амьсгалын замыг хамгаалах”-д онцгойлон анхаарч ажлын байрны онцлогт тохируулан дараах төрлийн хамгаалах хэрэгслээр тусгайлан хангах арга хэмжээг авна.

Хүснэгт 12. Үйлдвэр, технологийн орчны ажилчдад олгох амьсгал хамгаалах хэрэгсэл

Хамгаалах хэрэгсэлд тавигдах шаардлага	Хамгаалах хэрэгсэлийн онцлог
Тоосны тархалт ЗДХ-нээс хэтэрсэн ажлын байранд хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй үед ажилтнуудад амьсгал хамгаалах хэрэгсэл (АХХ) хэрэглүүлнэ. Ажлын ээлжийн турш АХХ-ийг тасралтгүй хэрэглэхийг зөвшөөрөхгүй.	Амьсгал гаргах хавхлагатай шүүлтүүрэн хошуувч. Тоосны шүүлтүүрэн хагас хошуувчийг солих боломжгүй шүүлтүүрийн материалаар хийгдсэн, Энэ төрлийн АХХ нь хатуу, шингэн төлөвтэй, ууршимтгай шинж чанартай тоосонцроос хамгаалах зориулалтай. Тоосны шүүлтүүрэн хагас хошуувч нь амьсгал гаргах хавхлагатай байдаг. Энэ хавхлага нь амьсгал гаргах эсэргүүцлийг багасгах зорилготой. Ийм төрлийн хавхлага нь хошуувчийг хэрэглэх үеийн ачааллыг бууруулах ач холбогдолтой юм
I зэрэглэлийн өртөлттэй ажлын үед АХХ хэрэглэх шаардлагагүй боловч, ажилтин сайн дураараа хэрэглэж болно. II, III зэрэглэлийн өртөлттэй ажлыг үед ажил олгогч тоосонд өртдөг ажилтнуудад зохих АХХ-ийг хэрэглүүлнэ. Кварц агуулсан тоосны II зэрэглэлийн өртөлттэй үед ажил олгогч ажилтанд АХХ хэрэглүүлэх үүрэгтэй.	P2 шүүлтүүртэй бүрэн нүүрэвч (FFP2). II зэрэглэлийн өртөлттэй эрдсийн болон цахиурын тоостой нөхцөлд P2 эсвэл түүнтэй дүйцэхүйц шүүлтүүрээс багагүй үр ашигтай бүтэн нүүрэвчийг хэрэглэнэ. Мөн P2 шүүлтүүртэй маск (шүүлтүүрэн хошуувч)-ыг II зэрэглэлийн өртөлттэй тоостой нөхцөлд хэрэглэж болно. P3 шүүлтүүртэй бүрэн нүүрэвч (FFP3). Хавдар, мугацн үүсгэгч, үр удамд сөрөг нөлөөтэй хорт бодисоос хамгаалахад P3 эсвэл түүнтэй дүйцэхүйц шүүлтүүртэй бүтэн нүүрэвчийг ашиглана. Биологийн бохирдол бүхий тоосны III зэрэглэлийн өртөлттэй ажлын үед P3 эсвэл түүнтэй дүйцэхүйц шүүлтүүртэй бүтэн нүүрэвч бүхий АХХ-ийг хэрэглэнэ. Мөн P3 шүүлтүүртэй маск (шүүлтүүрэн хошуувч)-ыг II зэрэглэлийн өртөлттэй тоостой нөхцөлд хэрэглэж болно.

Үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотойгоор богино хугацаанд хийдэг зарим ажлуудын үед АХХ хэрэглэх шаардлага гардаг. Эдгээрт:

- Шүүлтүүрийн системийг цэвэрлэх;
- Тоосны тасалгаа, тоос цуглуулах савыг хоослох;
- Цэвэрлэх байгууламжийн орчимд шалгалт хийх ажлууд хамаарна;

АХХ хэрэглэхээс өмнө инженер, технологийн хамгаалах аргаар ажлын байрны агаарт тоосыг хангалттай хэмжээгээр бууруулж чадахгүй тохиолдолд хувь хүнд тохирсон, эргономик, эрүүл мэндийн шаардлага хангасан амьсгал хамгаалах хэрэгслээр ажилтнуудыг хангана. Амьсгал хамгаалах хэрэгсэлд дараах төрлүүдээр ажилчдаа хангана. Үүнд:

- **Амны маск P200.** Нарийн тоос тоосонцорыг 95%, утаа, усан суурьтай манангаас хамгаална. Оосрыг хэт авиа ашиглаж эх биетэй аолбосон. Том зайтай тул амьсгалахд хялбар. AS/NZS 1716 P28 NIOSH N95, EN 149:2001+A1:2009 FFP2 NR стандартыг хангасан гэрчилгээтэй.
- **Хагас маск.** Европын холбооны EN140 стандартыг хангасан, үзэгдэх орчин бууруулдаггүй, алерги үүсгэдэггүй, силикон материалаар хийсэн, хүний нүүхэнд сайн суудаг Portwest брэндийн хагас маск. Хос фильтр ашигладаг, фильтр нь тоосны, аммиакны органик дэгдэмхий бодисны, органик бус дэгдэмхий бодисны гэх мэт олон төрөлтэй. Хагас маскуудыг ариутгац эвэрлээд олон дахин хэрэгдэхдээ фильтруудийг сольж ашиглах боломжтой.
- **Хагас маскны фильтр P921.** Европын холбооны EN 14387 Type ABEK 1 стандарт хангасан P921нь ABEK төрлийн шүүлтүүр бөгөөд буцалгах температур 65 C-ээс дээш байгаа органик болон органик бус хүчиллэг хий, уур, хүхрийн давхар исэл, аммиак болон үүсмэл бодисуудаас хамгаалдаг.
- **Хагас маск P430.** Европын холбооны EN 140 стандартыг хангасан, зэгдэх орчин бууруулдаггүй, алерги үүсгэдэггүй силикон материаллаар хийгдсэн, хүний нүүрэнд сайн суудаг Portwest брэндийн хагас маск. Хос фильтр ашигладаг, фильтр нь тоосны, аммиакны органик дэгдэмхий бодисны, органик бус дэгдэмхий бодисны гэх мэт олон төрөлтэй.
- **Хагас маскны фильтр P920.** (4 ширхэгтэй) Европын холбооны EN 143:2000 болон EN 14387:2004 стандартыг хангасан универсал маск. Уг маск ABEK1 төрлийн бүх хий, 65 хэмд буцалдаг органик гаралтай хий, органик бус гаралтай хий нүүрстөрөгчийн дан ба давхар ислийг тооцохгүй хүхэр, хүчлийн хийнүүд, аммиак зэргийг шүүдэг.

Хүснэгт 13. Амьсгал хамгаалах хэрэгслээр ханган нийлүүлэх хэмжээ, 2024 оны хэрэгцээгээр

№	Хамгаалах хэрэгсэл	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо ширхэг	Нийт үнийн дүн
1	Амны маск P200	Ш	30,000.0	300	900,000.0
2	Хагас маск P430	Ш	18,000.0	50	900,000.0
3	Хагас маскны фильтр P921.	Ш	15,000.0	144	2,160,000.0
4	Хагас маск P430.	Ш	30,250.0	70	2,117,500.0
5	Хагас маскны фильтр P920.	Ш	37,200.0	70	2,604,000.0
2024 оны хамгаалах хэрэгслийн тооцсон зардал, төгрөгөөр					8,681,500.0

Төв аймгийн Баянцогт сумын нутаг дахь “Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ
 “ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

Хүснэгт 14. Осол, эрдлээс сэргийлэх арга хэмжээний зардал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ажлын байрны хортой нөхцөл	Хор саармагжуулах хүнсний хангамж	Үйлдвэрийн технологийн ажилчид	хүн/сар	168	35,700.0	5,997,600.0	өдөр бүр	<ul style="list-style-type: none"> Төв аймгийн ОБГ-ын 1912767 тоот галын дүгнэлт “Нерж” ХХК, БОННУ-ний тайлан MNS 6783:2019 MNS 5105:2001 MNS 6342:2012 MNS 6594:2016 MNS 0042:2015 MNS 4978:2017 MNS 4596:2015 MNS 4968:2015 MNS 4992:2000
2	Галын болзошгүй эрсдэл	Нөхцөл байдлыг стандартын горимд нийцүүлэх	ТП байрны засвар үйлчилгээ	бүхэл	1	2,000,000.0	2,000,000.0	жилдээ	
3	Ажлын байрны хортой нөхцөл	Хөдөлмөр хамгааллын хэрэгслийг шинэчлэх	Амьсгалын замыг хамгаалах хэрэгслийг шинэчлэх	хүн/жмл	584	13,324.48	8,681,500.0	жилдээ	
Нийт			5,997,600.0 + 2,000,000.0 + 8,681,500.0 = 16,679,100.0						

2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрийн аюултай хог хаяглын асуудлаар. Батарей задалснаас гарсан хүхрийн хучлийг хуримтлуулсаар байгаад 200.0 орчим тн орчим болоод байгааг саармагжуулах зорилгоор хими-технологийн салбарын судлаачидтай хамтран ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд химийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтантай гэрээ байгуулан цалинжуулан ажиллуулж байгаагаар цалингийн фондоо нэмэгдүүлсэнээр аюултай хог хаягдал устгах ажлын зардлыг үйл ажиллагааны зардалд тусгаж өгсөн болно.

Хуримтлагдсан хүхрийн хучлийг 2024 онд дараах байдлаар устгал ашиглалтанд оруулахаар ажиллана. Үүнд:

- 120 тн-ыг “Ачих ихт” нийлүүлэх ажлыг эхлүүлж гэрээний нөхцөл судална.
- 80.0 тн-ыг устгалд оруулах бөгөөд устгалд оруулахтай холбоотой зардлыг үйлдвэрийн 2024 оны үйл ажиллагааны зардалд тусгалаа.

Ахуйн хог хаягдлын асуудлаар. Үйлдвэрийн хог хаягдлын менежментийг 2024 онд орчны ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажилд чиглүүлнэ. Үүний тулд:

1. Ажилчдын нийтийн хэрэглээний энгийн нүхэн жорлон орчны газрыг ариутгал, халдваргүйжүүлэлтэнд 2 сар тутам хамруулахад сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллана.
2. Септик системтэй хуримтлагдсан лагийг цэвэрлэн зайлуулах арга хэмжээг жилд 2 удаа хийх бөгөөд түүнд 3.0 сая төгрөг төсөвлөлөө.

Бусад ахуйн хог хаягдлыг зайлуулахад сумын Засаг даргатай байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллана. Гэрээг 2022-07-27-ноос 2024-01-01-г хүртэл байгуулсан бөгөөд гэрээнд хог хаягдлын менежментийн талаар дараах асуудлуудыг тусгасныг мөрдөж ажиллана. Үүнд:

- ААН байгууллагын зайлуулсан устгалд орох хог хаягдлыг Гужа багийн нутаг дахь сумын нэгдсэн хогийн цэгт хүргэнэ. Сарлаг багийн нутаг дахь хог хаягдлын цэгийн даац хэтэрснээр сумын захиргаанаас тавьсан саналд үндэслэн хогийн цэгийг техникээр түрж хумих ажилд компани тусална.
- Компани үйлдвэрлэлээс гарч байгаа хог хаягдлын мэдээг сумын Засаг даргад хуульд заасан шаардлагын дагуу холбогдох хугацаанд нийлүүлж байна.
- Дахин ашиглах боломжтой дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилж хоёрдогч түүхий эд хүлээн авах эрх бүхий этгээдэд шилжүүлэх ажлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан гүйцэтгэнэ.

Үйлдвэрлэлээс гарах буталсан хуванцарыг компани өөрийн хашаанд түр хадгалж байгаад ачилтын хэмжээнд хүрэхэд нь хуванцар боловсруулах үйлдвэрт нийлүүлэх эрэл хайгуулыг хийж энэ ондоо багтаан гэрээ хийнэ.

Төв аймгийн Баянцогт сумын нутаг дахь “Хаягдал аккумулятор, өнгөт төмөрлөг дахин боловсруулах” үйлдвэрийн 2024 онд хэрэгжүүлэх БОМТ
“ҮЛЭМЖ ХҮДЭР” ХХК

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ.	Ажилдчын хэрэгцээний нүхэн жорлонгийн орчин	удаа	50,000.00	6	300,000.0	2 сард 1 удаа	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын тухай хуулийн 20.1, 20.2, 21.1 заалтууд “Нерж” ХХК-д боловсруулсан БОННУ-ий хог хаягдлын менежментийг мөрдөх тухай зөвлөмж Төв аймгийн Баянцогт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 16 дугаар тогтоол Сумын ЗД А.Даваадоржтой байгуулсан 2023-11-15-нд Хог хаягдлын гэрээ Туул голын сав газрын захиргааны ХУД/21 дугаартай Хаягдал усны дүгнэлт
		Хуримтлагдсан бохир лагийг цэвэрлэнэ.	Септик систем, түүний орчин	удаа	1,500,000	2	3,000,000.0	Хагас жилд 1 удаа	
2	Үйлдвэрийн	Шингэн хаягдлын саармагжуулт, агуулахын орчны хяналт	Дотоод хяналтын журам		Дотоод хяналт, үйлдвэрлэлийн зардалд тооцсон.		Байнга		
